



ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 06 САР | ДУГААР 31

ГАРЧИГ

- 2–3 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээгээр зөрчил, дутагдал гаргасан хуулийн этгээдүүдэд шаардлага хүргүүллээ
- 3–6 Зохицуулалтын мэдээ
- 7–8 Компаниуд ногдол ашиг хувиарлах бодлоготой байх ёстой
- 9–10 Тайлбар ба зөвлөмж
- 11–12 Ногоон, дижитал хөрөнгийн зах зээлийн шилжилт
- 13 Финтек Регтек
- 14 Компанийн засаглал
- 15 Олон улсын зах зээлийн мэдээ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ ГАРГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДЭД ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын салбаруудын хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, бодлого зохицуулалтын орчинг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, байгууллагын болон салбарын эрсдэлийг үнэлж үр дүнд үндэслэн хяналт шалгалт хийж алдаа дутагдлыг залруулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага. Зохицуулагч байгууллагын хувьд улс орны санхүүгийн зах зээлийн тогтвортой, аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллахаар зорьдог бөгөөд үүний нэг чухал хэсэг нь Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)–аас гаргасан стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх, зохицуулалттай этгээдүүдийн үйл

ойлгох шаардлагатай бөгөөд эрсдэлээ үнэлэх эрх бүхий байгууллагыг тодорхойлж, энэ талын зохицуулалтыг хийж, нөөц боллоцгоог зөв хуваарилах, эрсдэлээ үр дүнтэй бууруулах арга хэмжээ авбал зохино. Эрсдэлийн үнэлгээнээс эрсдэлд суурилсан аргачлалыг нэвтрүүлэх замаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшин тохирсон урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай” гэж заасан байдаг.

Санхүүгийн зохицуулах хороо үүнтэй холбогдуулж 2017 оноос хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлж зохицуулалттай этгээд тус бүрийн эрсдэлээс гадна салбарын болон үндэсний эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэн ажиллаж байна. Эрсдэлийг ийнхүү үнэлэх нь урьдчилан сэргийлэх, илэрсэн эрсдэлийг бууруулах, стратеги боловсруулж хэрэгжүүлэх, ФАТФ–ын дараагийн буюу 2023 онд хийгдэх үнэлгээнд бэлтгэхэд туслалцаа үзүүлэх ач холбогдолтой.

Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг 2016 онд анх хэрэгжүүлж байсан бол уг үнэлгээг шинэчлэх зорилгоор 2020 оноос эхлэн Дэлхийн банкны аргачлалаар нийт 10 модуль буюу салбар, чиглэл тус бүрийн хүрээнд үнэлгээг хийж эхэлсэн. Тодруулбал, дээрх 10–аас 6 модулийн буюу зохицуулалтын 6 салбарын эрсдэлийн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хорооноос хариуцаж 82 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлж байна. Энэхүү эрсдэлийн үнэлгээ нь мэргэжлийн холбоод, зохицуулалттай салбаруудын төлөөллийг ажлын хэсэгт хамруулан холбогдох дата, статистик тоо мэдээг олон төрлийн эх үүсвэрээс цуглуулж, баталгаажуулж ажилласнаараа онцлогтой юм.



ажиллагаанд нэвтрүүлэх явдал юм. ФАТФ нь олон улсад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 40 зөвлөмж буюу стандартыг боловсруулсан бөгөөд хэрэгжилтэд нь байнга хяналт тавьж, хариуцлагын арга хэмжээг тооцохдоо улс орнуудыг стратегийн дутагдалтай орнуудын “Саарал жагсаалт”, хамтарч ажилладаггүй орнуудын “Хар жагсаалт”–д оруулдаг. ФАТФ–ын 40 зөвлөмжийн Зөвлөмж 1–д “Улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлж, үнэлж,

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- Засгийн IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- +976-51-264444
- press@frc.mn
- www.frc.mn
- Санхүүгийн зохицуулах хороо
- @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

Үргэлжлэл 2–р нүүрт >>



**ТАНЫ
САНХҮҮГИЙН
МЭДЛЭГТ**

МУУ ЗЭЭЛ

Монгол: Эдийн засгийн үнэ цэнэгүй болсон тул бодит алдагдал болон ангилагдсан зээл. Ийм зээлийн хугацаа хэтэрч төлөгдөөгүй үлдсэн хүүгийн болон үндсэн төлбөрийн нийт дүн нь зээлийн багцаас хасагдаж, зээлийг эрсдэлийн санг мөн хэмжээгээр бууруулдаг.



BAD LOAN

Loan classified as a probable loss having no economic values. These loans, past due as to payment of interest and principal, are removed from the loan portfolio and their book value loss is charged to a reserve account.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ


МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ ГАРГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДЭД ШААРДЛАГА ХҮРГҮҮЛЛЭЭ

Эхлэл 1-р нүүрт >>

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, заавраар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 2018 оны 339 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан. Энэ журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос эрсдэлийн үнэлгээг салбарын болон зохицуулалттай этгээд тус бүрийн түвшинд хийж гүйцэтгэж байна. Тухайлбал, 2019 онд хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран салбарын эрсдэлийн үнэлгээг анх удаагаа хийсэн. Ингэхдээ зохицуулалттай салбар тус бүр үйл ажиллагааны эрсдэлийг үнэлж, эрсдэл үүсэх давтамж, түүний үзүүлэх үр нөлөөг үнэлсэн юм. Харин үнэлгээг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшил, холбогдох төрийн бусад байгууллагаас санал, дүгнэлт авч тайланг боловсруулсан бөгөөд үр дүнг оролцогчдод танилцуулж, салбар тус бүрт баримтлах бодлогыг тодорхойлж ажилласан. Зохицуулалттай этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлэх, салбарын эрсдэлийн ерөнхий түвшинг тогтоох, хяналт шалгалтад шаардагдах мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, цаашдын сургалтын хөтөлбөрийн агуулгыг боловсруулах зорилгоор 2018 оноос эхлэн “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг google form ашиглан улирал бүр авч байсан бол өнгөрсөн онд ОУВС-ийн төслийн хүрээнд Монгол Улсад зориулсан аргачлалын дагуу үнэлгээний асуулгыг

шинэчлэн боловсруулсан. Үүний дагуу үнэлгээний маягыг excel файл хэлбэрээр цуглуулахаас гадна давтамжийг хагас жил тутам буюу жилд хоёр удаа болгож бууруулсан. Эрсдэлийн үнэлгээ нь онооны системд суурилсан тоон болон чанарын асуулгаас бүрдэх бөгөөд үр дүнд үндэслэн тухай бүр эрсдэлийн мэдээллийн санг шинэчилнэ. Өөрөөр хэлбэл нийт этгээдүүдийг эрсдэл өндөр, дунд, бага гэсэн 3 түвшинд үнэлэн матрицад байршуулж эрсдэл өндөртэй гарсан тохиолдолд газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд оруулан хяналтын давтамжийг нэмэгдүүлэх, эрсдэл багатай этгээдүүдийг зайнаас хянах зэргээр нөөцийг үр ашигтайгаар хуваарилах боломжийг бий болгодог. Ийнхүү Хорооноос ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн эрсдэлийг үнэлж, түүнд тохирсон арга хэмжээг авах, эрсдэлд суурилсан аргачлалыг зохицуулалтын салбаруудад хэрэгжүүлэх, хэвшүүлэх ажлыг тасралтгүй хийсээр байна. Эрсдэлийн үнэлгээний асуулгыг авахдаа Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудас /www.frc.mn/-ны “Мэдээ, мэдээлэл” эсвэл “Мөнгө угаахтай тэмцэх” цэсний “Хяналт шалгалт” бүлгээр олон нийтэд нээлттэй мэдээлэхээс гадна мэдээллийн урсгал, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс Хорооны цахим сүлжээнд байршуулдаг. Түүнчлэн танигдаагүй өнгөрөх эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлж зохицуулалттай этгээд тус бүрийн цахим шуудангаар 2-3 удаагийн мэдээлэл, анхааруулгыг хүргүүлж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг. Гэхдээ эрсдэлийн үнэлгээг заасан хугацаанд бөглөхгүй байх, дутуу





ирүүлэх, бодит байдлаас зөрүүтэй мэдээлэл өгөх, зөрчил, дутагдал илэрвэл тухайн этгээдийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй буюу өндөр эрсдэлтэй гэж үзэж хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлэх нөхцөл бүрддэг. Түүнчлэн хянан шалгагчийн зүгээс хугацаатай үүрэг даалгавар, мэдэгдэл, улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэх ба удаа дараа зөрчил гаргаж хамтран ажиллахаас татгалзсан тохиолдолд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос

авах боломжтой. Цаашлаад Зөрчлийн тухай хуулийн дагуу учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, иргэнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор заасан байдаг.

2021 оны эрсдэлийн үнэлгээний асуулгыг нэгдүгээр сарын 28-наас хоёрдугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд цуглуулсан. Асуулгыг шаардсан хугацаанд бөглөж ирүүлээгүй, дутагдал гаргасан нийт 31 хуулийн этгээдэд хугацаатай үүрэг даалгавар бүхий мэдэгдэл хүргүүлэхийн зэрэгцээ зөрчил илэрсэн этгээдүүдэд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгаж биелэлтийг тооцож ажиллалаа.

Цаашид эрсдэлийн үнэлгээний асуулгыг ирүүлээгүй, хамтран ажиллахаас татгалзсан, мэдэгдэл болон улсын байцаагчийн албан шаардлагаар өгсөн хугацаатай үүрэг даалгавар биелүүлээгүй этгээдүүдийг бүртгэлээс хасах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч ажиллана.

Иймд 2021 оны сүүлийн хагас жилийн эрсдэлийн үнэлгээний асуулгыг ирэх долдугаар сард багтаан авч эхлэх тул мэдээлэх үүрэгтэй этгээдүүд тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэд бөглөн ирүүлэхэд анхаарах шаардлагатай байгааг зөвлөж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН НЭЭЛТИЙН ЁСЛОЛ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны энэ сарын 23-ны ээлжит хуралдаанаар “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК-ийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэж, олон нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн. Үүний дагуу хөрөнгийн зах зээлд бий болж буй хоёр дахь хамтын хөрөнгө оруулалтын сангийн

нэгж эрхийн анхдагч арилжааг эхлүүлэх цан цохих ёслол өнөөдөр боллоо.

Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, Мандал санхүүгийн нэгдэлийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг, “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Ганзориг болон бусад хүмүүс оролцсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан нээж хэлсэн үгэндээ “Хэдийгээр коронавируст цар тахлаас шалтгаалж нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн, амаргүй олон сорилттой тулгарсан ч хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ 3.7 их наяд төгрөг, нийт арилжааны хэмжээ 634.7 тэрбум төгрөг, хувьцааны хөрвөх чадвар 1.8 хувь, ДНБ-д харьцуулсан харьцаа 10 хувьд хүрч түүхэн дээд түвшинд хүрсэн. Хөрөнгийн зах зээлийн хөгжил нь иргэд, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын хүлээлт, итгэлцэл

дээр суурилж өсч, тэлж хөгждөг онцлогтой зах зээл бөгөөд энэхүү хүлээлт, итгэлцлийг бий болгоход УИХ, Засгийн газар, төрийн зохицуулагч байгууллагуудын оновчтой бодлогын арга хэмжээ нөлөөлснөөс гадна салбарын мэргэжлийн байгууллагуудын хүчин чармайлт чухал үүрэг гүйцэтгэснийг онцлох хэрэгтэй.



Иргэд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалтын сан, мэргэжлийн институцээр дамжуулж оролцооноор оновчтой шийдвэрийг тооцоо судалгаан дээр үндэслэн гаргуулах, эрх ашгаа нэгдмэл байдлаар хамгаалуулах зэрэг давуу тал олон. Ийм учраас Хорооноос “Мандал ассет менежмент ҮЦК” ХХК-ийн

үүсгэн байгуулсан хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэж, нэгж эрхээ олон нийтэд санал болгон гаргах зөвшөөрлийг олгож, өнгөрсөн хугацаанд тодорхой хэмжээнд бий болж буй хөрөнгийн зах зээлд хандах иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүлээлт, итгэлцлийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажиллана гэдэгт итгэж байна” гэлээ.

“Мандал ирээдүйн өсөлт хамтын ХОС” ХХК нь нэгж эрх тус бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 50 сая ширхэг нэгж эрх гаргаж, үүний 95 хувийг буюу 47 сая 500 мянган ширхэг нэгж эрхийг олон нийтэд санал болгож, нийт 47.5 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлэх юм.

ИРГЭД, ОЛОН НИЙТИЙГ ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Тусгай зориулалттай цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг эрхлэж буй ББСБ жагсаалт

2021 ОНЫ 2 ДУГААР УЛСРЫН БАЙДЛААР

1. "Ардкредит ББСБ" ХХК	21. "Профит фэйнаиншвал холдингс ББСБ" ХХК
2. "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК	22. "Сайн финансе энд трансфер ББСБ" ХХК
3. "Тунгудан финансе ББСБ" ХХК	23. "Сам шор ББСБ" ХХК
4. "Телекредит ББСБ" ХХК	24. "Соломон инвестментс ББСБ" ХХК
5. "Дигитал маркет ББСБ" ХХК	25. "Сонгоолон финансе ББСБ" ХХК
6. "Жи Эс Би капитал ББСБ" ХХК	26. "Сэлл эм эн ББСБ" ХХК
7. "И Эс Эв финансе ББСБ" ХХК	27. "Тн финансе ББСБ" ХХК
8. "Инвестор хөгжөөч ББСБ" ХХК	28. "Турьсл ББСБ" ХХК
9. "Инвестос ББСБ" ХХК	29. "Фэйнаиншментал групп ББСБ" ХХК
10. "Ирээдүйн инвест ББСБ" ХХК	30. "Хатан сула ББСБ" ХХК
11. "Ив мөнгөтө кредит ББСБ" ХХК	31. "Хийморьт тайвант шарга ББСБ" ХХК
12. "Кредитсх СТМ ББСБ" ХХК	32. "Централ капитал ББСБ" ХХК
13. "Инданс ББСБ" ХХК	33. "Шинэ тоглог ББСБ" ХХК
14. "Мобифинансе ББСБ" ХХК	34. "Эксклюзивити ББСБ" ХХК
15. "Монитоло ББСБ" ХХК	35. "Эм Пн Эс Сп ББСБ" ХХК
16. "Паралсансар ББСБ" ХХК	
17. "Нэг капитал финансе корпоратш ББСБ" ХХК	
18. "Орлогшил холдш ББСБ" ХХК	
19. "Очир улсраа ОМЗ ББСБ" ХХК	
20. "Навбитс кредит ББСБ" ХХК	

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-ын дагуу “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” нь банк бус санхүүгийн үйл ажиллагаанд

хамаардаг бөгөөд тус үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.6 дугаар зүйлийн 11.6.1-д заасны дагуу “Хадгаламж, зээл, төлбөр тооцооны, эсхүл хуульд заасны дагуу зөвшөөрөл, тусгай зөвшөөрөлтэй явуулах санхүүгийн бусад үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр, эсхүл хууль бусаар явуулсан бол олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж иргэнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

Тусгай зөвшөөрөлгүй этгээдээс энэ төрлийн үйлчилгээг авснаар залилан, хууран мэхлэлт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй тул иргэд, олон нийтийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэйгээр цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлж буй этгээдүүдийн жагсаалтыг тогтмол шинэчлэн цахим хуудаснаа нээлттэй мэдээлдэг. Энэ удаад 2021 оны зургадугаар сарын 25-ны өдрийн байдлаарх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүдийн нэрсийг шинэчлэн хүргэж байна.

Иймд иргэн Та цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг авахаасаа өмнө тухайн байгууллагын нэрийг дээрх жагсаалттай тулгахаас гадна тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шалгах замаар өөрийгөө болзошгүй эрсдэлээс хамгаалах боломжтой. Мөн тусгай зөвшөөрөлгүй атал үйлчилгээ үзүүлж байж болзошгүй этгээдийг илрүүлсэн тохиолдолд СЗХ-нд бичгээр болон цахимаар мэдэгдэж, өөрийгөө болон бусдыг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулаарай.

БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ

@ amlctf@frc.mn
+51-261112
+51-261113

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ЦАН ЦОХИХ ЁСЛОЛ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны энэ сарын 23-ны ээлжит хуралдаанаар “Лэндмн ББСБ” ХК-д 100.000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50.000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэж, нийтэд санал болгож арилжаахыг зөвшөөрсөн.

Тус компанийн олон нийтэд санал болгон гаргаж буй өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны цан цохих ёслолын ажиллагаа өнөөдөр боллоо. Энэхүү ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга С.Цэрэндаш, “Лэндмн ББСБ” ХК-ийн гүйцэтгэх захирал О.Болдбаатар, ТУЗ-ийн дарга Ц.Одмаа, “Өлзий энд ко капитал ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр болон албаны бусад хүмүүс оролцсон юм.

Энэ үеэр СЗХ-ны Үнэт цаасны газрын дарга С.Цэрэндаш “Сүүлийн жилүүдэд үндэсний томоохон аж ахуйн нэгжүүд дотоодын хөрөнгийн зах зээлд өрийн хэрэгсэл буюу бонд гаргах замаар урт хугацааны санхүүжилт татах сонирхол нэмэгдсэн. Жишээлбэл, Хорооноос энэ оны хагас жилийн байдлаар гурван аж ахуйн нэгжийн өрийн хэрэгслийг бүртгэж, олон нийтэд санал болгож гаргах зөвшөөрлийг олгоод байна.

Компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, банкны зээлтэй өрсөлдөхүйц санхүүжилтийн тогтолцоог бий болгох харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм, журмыг зах зээлийн нөхцөл байдал, олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр боловсруулсан “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг Санхүүгийн зохицуулах хороо энэ сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаараа баталсан. Энэхүү журмаар тодорхой шаардлага хангасан бонд

гаргагчийн нийтэд санал болгон гаргах бондыг хялбаршуулсан горимоор богино хугацаанд бүртгэх, өрийн хэрэгслийг үе шаттайгаар гаргах, дотоодын аж ахуйн нэгжүүд “Ногоон бонд” гаргах, аж ахуй нэгжүүд цаг хугацаа, зардал хэмнэж, богино хугацаанд санхүүжилт татах боломжийг бүрдүүлснээрээ давуу талтай” гэдгийг онцолсон юм.


Д.БАЯРСАЙХАН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮСИЙН САНААЧИЛГЫН ДАРГААР СОНГОГДЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан өнөөдөр Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн Зүүн европ, төв азийн бүсийн санаачилга /ECAPI/-ын даргаар сонгогдлоо. Тодруулбал, бүсийн санаачилгын 7 дахь удаагийн хурал цахим хэлбэрээр өнөөдөр болж хурлын гишүүд ийнхүү сонгосон юм.

Бүсийн санаачилгын хурал жилд 2 удаа зохион байгуулагддаг бөгөөд энэ удаагийн хурлаар хийж хэрэгжүүлсэн ажлын явц, биелэлт, ирэх жилийн төлөвлөгөөний талаар хэлэлцлээ. Мөн гишүүн байгууллагууд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан бодлогын өөрчлөлт, шинэчлэл, шинэ санаачлагууд болон “Ковид-19” цар тахлын үеийн болон дараах арга хэмжээнүүдийн талаар санал солилцохын зэрэгцээ өнгөрсөн 2 жилийн хугацаанд бүсийн санаачилгыг тэргүүлж байсан Бүгд Найрамдах Армени Улсын Төв банкны дэд ерөнхийлөгч Вахтанг Абрамяны ажлыг хүлээлцэх ёслол болсон юм.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хурлын үеэр Зүүн европ, төв азийн бүсийн санаачилгын даргын хувьд бүс нутаг дахь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх чиглэлд цаашид анхаарч ажиллахаа илэрхийллээ.



Харин хоёр дахь өдрийн хурлаар гишүүн байгууллагууд, хөгжингүй орнууд болон хувийн хэвшлийн төлөөллүүд дижитал санхүүгийн үйлчилгээ, орон нутагт санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, бичил бизнесийг дэмжих чиглэлээр туршлага солилцлоо. Мөн дэлхий нийтийн чиг хандлага, инновацийг судалж, бүс нутгийн хувьд нэн чухал асуудал болох шинээр нэвтэрч буй зохицуулалт (RegTech), хяналтын технологи (SupTech)-оос үүдэлтэй өөрчлөлтүүд эдгээртэй уялдсан үр дүнтэй шийдлүүд, арга замуудын талаар хэлэлцэв.

Бүсийн санаачилгын бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Казакстаны Санхүүгийн зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх агентлаг, Армени, ОХУ, Узбекистаны Төв банк, Беларусын Үндэсний банк, Тажикстаны Үндэсний банк багтдаг.

НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ 'НОГООН БОНД' ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛСАН ЖУРАМ БАТЛАГДЛАА



Ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор "Ногоон бонд"-ын зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хороо бондын бүртгэлийн журамдаа тусгаж баталсныг Олон улсын санхүүгийн корпораци /IFC/ онцолсон байна.

Энэхүү нийтлэлд "...Хэдийгээр олон улсын хэмжээнд ногоон бонд нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх зэрэгт шаардагдах хөрөнгө оруулалтыг

татан төвлөрүүлэхэд өргөнөөр ашиглагдаж байгаа боловч Монгол Улсын хувьд одоогоор ногоон бонд гаргасан тохиолдол бүртгэгдээгүй байгаа билээ. Хэдий тийм боловч ногоон бонд гаргах сонирхол, эрэлт хэрэгцээ маш их байгаа бөгөөд жилд ойролцоогоор 1 тэрбум ам.долларын ногоон санхүүжилтийн хэрэгцээ байна гэсэн судалгаа гарсан.

"Монгол Улсын Засгийн газраас ногоон эдийн засгийг дэмжихэд чиглэсэн хэд хэдэн бодлого, хөтөлбөрүүд гаргасан байдаг. Энэхүү журам батлагдсанаар ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал алхам болж байгаа юм" гэж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хэлсэн байна. "Хөрөнгийн зах зээлд илүү олон оролцогчдыг оролцуулах, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд бид ногоон бонд гаргахад тавигдах шаардлагыг тодорхой болгож Олон улсын санхүүгийн корпорацитай хамтран ажиллаж байна" гэжээ.

Өнгөрсөн 12 дугаар сард зохион байгуулагдсан Уур амьсгалтай холбоотой зорилтуудыг хэлэлцэх олон улсын чуулган дээр Монгол Улс Парисын хэлэлцээрийн хүрээнд тодорхойлсон Хүлэмжийн хийг бууруулах үүрэг амлалтаа 2030 он гэхэд 27.2 хувьд хүргэхээр нэмэгдүүлэн тодорхойлсон билээ. Энэхүү шинэ үүрэг амлалтыг биелүүлэхэд 11.5 тэрбум ам.долларын санхүүжилт шаардагдах тухай холбогдох судалгаануудад дурдсан байна.

"Монгол Улсын газар зүй, цаг уурын онцлог нь сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлттэй төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд таатай боломжийг бий болгож байдаг" хэмээн Олон улсын санхүүгийн корпорацийн Санхүүгийн байгууллагуудад зөвлөгөө өгөх газрын Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан дарга Камар Салем хэлжээ. Мөн тэрээр "энэхүү боломжийг ашиглаж ногоон бонд гаргах эсвэл ногоон бондод хөрөнгө оруулах сонирхолтой санхүүгийн болон хувийн хэвшлийн бусад байгууллагууд олон байгаа бөгөөд энэ нь Монгол Улсад байгаль орчинд илүү ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, хог хаягдал багатай хүрээлэн буй орчныг бүрдүүлэхэд туслах болно" гэсэн байна.

БАЙР СУУРЬ

Б.ДОЛГОРСҮРЭН: КОМПАНИУД НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ БОДЛОГОТОЙ БАЙХ ЁСТОЙ



Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгурсүрэнтэй хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар ярилцлаа

Монголын хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээллээр 185 хувьцаат компани бүртгэлтэйгээс 141 нь хуульд заасан

хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлаа (ХЭХ) зарласан гэж байсан. Компаниуд ХЭХ-ынхаа шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хуульд заасан хугацаанд буюу хурал зохион байгуулснаас хойш ажлын гурав хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/-нд хүргүүлэх ёстой байдаг шүү дээ. Хуульд заасан эцсийн хугацаа буюу өнгөрсөн дөрөвдүгээр сарын 30-нд багтаан ХЭХ-аа хийгээгүй, танайд мэдээллээ ирүүлээгүй компани хэд байгаа вэ?

Хороонд 159 компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдлээ ирүүлсэн. Тэдгээрийн 120 нь хурлын материалаа ирүүлсэн бөгөөд зургаагийнх нь хурал хойшилсон. Тавдугаар сард 72 компанийн ХЭХ-ын материалыг хянаад, холбогдох нэмэлт материалаа ирүүлэхийг шаардсан. Материалыг хянахдаа хурлын ирц нь бүрдсэн үү, хэлэлцэх ёстой асуудлуудаа ярилцсан уу, төлөвлөөгүй асуудлын талаар хэлэлцсэн үү, зохих тооны хараат бус гишүүнийг сонгосон уу, сонгохдоо аль нэг шаардлагыг зөрчсөн эсэх, мэдээллийн ил тод байдлыг яаж хангасан, сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийсэн бол түүнийгээ хэрхэн хийсэн, энэ талаараа хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлсэн, эсэх зэргийг хянадаг. Зарим компаниуд хараат бус гишүүнийг зохих шаардлагад нийцүүлэн сонгоогүй зөрчил гарч байна.

СЗХ-ноос жил бүрийн эхэнд ХК-иудад хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулахтай холбоотой мэдэгдэл буюу зөвлөмж хүргүүлдэг. Ингэснээр ХК-иудыг ХЭХ-аа холбогдох хууль журамд нийцүүлэн хуралдуулахад дэмжлэг үзүүлж байна.

Тэгэхээр хуульд нээлттэй байлгахгаар заасан бүх мэдээллийг компаниас өгдөг байх хэрэгтэй, тийм үү?

Тийм ээ, нээлттэй өгч болох мэдээллийг танилцуулдаг байх хэрэгтэй. Компанийн нэг эсвэл цөөн тооны хувьцааг худалдан

авчихаад “Би хувьцаа эзэмшигч. Бүх мэдээллийг авах хэрэгтэй” гээд СЗХ-нд өргөдөл ирүүлж, компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд санаатайгаар саад учруулах тохиолдол гардаг. Гагцхүү ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг компаниас мэдээллээ нууцлах гэдэг ч юм уу шаардлага үүсдэгийг зарим хүн ойлгох хэрэгтэй болов уу.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангуулах тал дээр хэрхэн анхаарч буй бол?

ХЭХ-аар ТУЗ-ийн гишүүдийг Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам мөрдөж сонгосон эсэхэд хяналт тавьж жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллаж байна.

Компанийн тухай хуульд заасны дагуу ХЭХ-аа хугацаанд нь хийгээгүй компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийнх нь хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болдог. Тэдгээр компанийн талаарх мэдээллийг СЗХ хэзээ олон нийтэд хүргэх вэ?

ХЭХ-аа холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарлан хуралдуулаагүй 84 ХК-ийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг ээлжит бусаар зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрхгүй болсныг СЗХ-ны цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ. ХЭХ-аа зохион байгуулдаггүй, үйл ажиллагаа явуулдаггүй ХК-иудыг цэгцлэх ажлыг энэ ондоо багтаан хийхээр төлөвлөн ажиллаж байна.

ХЭХ-ын үеэр ямар эрх эдлэх, ямар мэдээлэл авах ёстойгоо зарим хувьцаа эзэмшигч мэдэхгүй байхыг үгүйсгэхгүй.

Тэд ХК-ийн удирдлагаас ямар мэдээлэл авахыг хүсэх, ямар шаардлага тавих ёстой талаар тодруулна уу?

Компанийн энгийн хувьцаа эзэмшигч ХЭХ-д оролцон, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх, жилийн тайлангийн талаар мэдээлэл авах, давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараа ТУЗ-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах зэрэг эрхтэй.

Жижиг хувьцаа эзэмшигчдийн санал ХЭХ-ын үеэр шийдвэр гаргахад нөлөөлөхгүй байх тохиолдол олонтоо. Уг нь тэдний эрх ашгийг хамгаалах зохицуулалт бий. Энэ талаар тодруулахгүй юу?

Аль нэг компанийн жижиг хувьцаа эзэмшигчдэд нийт үнэт цаасны 5–10 хувь нь ч юм уу ногдож байгаа. Тэд кастодиан банкуудад эрхээ хадгалуулан, үнэт цаасаа “нэгтгэчихвэл” нийт үнэт цаасны тоотой хувь тэнцүүлэн төлөөлж санал өгөх боломжтой. Тодруулбал, ТУЗ–д ядаж нэг гишүүн нэр дэвшүүлж, кумулятив аргаар сонгох боломжтой. Кастодиан банкууд таныг төлөөлөөд ХЭХ–д оролцоно.

Зарим компанийн удирдлага албаар ашиггүй ажилласан гэж хэлэхийг үгүйсгэхгүй. Үүнтэй холбоотой гомдлыг СЗХ–нд гаргах боломжтой.

Цар тахлаас гадна хувьцаа эзэмшигчид дэлхийн олон оронд амьдарч байгаа зэрэгтэй холбоотойгоор цаашид ч ХЭХ–ыг цахимаар зохион байгуулах болов уу. Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар ийм шийдвэр гаргалаа гэж Тооллогын комисс нь танилцуулдаг. Саналыг зөв тоолж байгаа эсэхэд хэн, хэрхэн хяналт тавих ёстой вэ?

СЗХ–ны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журамд 2021 оны 45 дугаар тогтоолоор ХЭХ–ыг цахим хэлбэрээр зохион байгуулах тухай нэмэлт, өөрчлөлт оруулсан. Компаниуд үүний дагуу ХЭХ–аа зохион байгуулсан.

Сүүлийн жилүүдэд зарим хувьцаат компани ХЭХ–аа үнэт цаасны компаниудаар зохион байгуулж, тооллогын комиссоор ажиллуулж байгаа. Тооллогын дүнг тухайн компани үнэн зөв гаргахад анхаарч, хариуцлага хүлээх учиртай.

ХЭХ–аа цахимаар сайн зохион байгуулсан компани хэр олон байв?

“Говь”, “ЛэндМН ББСБ”, “Инвескор ББСБ” зэрэг ХК маш сайн зохион байгуулсан.

Компаниудын ТУЗ–ийн үйл ажиллагааг сайжруулахын тулд юунд анхаарах хэрэгтэй гэж анзаарсан бэ?

ТУЗ–ийн гишүүдээ сонгохдоо анхаарах нь хамгийн чухал. ТУЗ–ийн гишүүнээр хамаатан саднаа, хараат бус гишүүнийг сонгохдоо танил талаасаа асууж сураглан сонгодог. Тэгэхээр тухайн гишүүнийг хараат бус гэж хэлэхэд өрөөсгөл болчихдог. Мөн ТУЗ–ийн үүрэг хариуцлагын талаар мэдлэггүй хүнийг сонгосноор ТУЗ нь маш өндөр чадвартай байх ёстой гэсэн зарчим алдагддаг. Иймээс ч сайн гүйцэтгэх удирдлага олж ажиллуулахыг л компаниудын ТУЗ–ийнхөн зорьж байна.

Дэлхийд томд тооцогддог “Microsoft” корпорацийн хувьцааны 10 гаруй хувийг л Билл Гейтс эзэмшдэг ч бүх шийдвэрийг гаргадаг. Бусад хувьцаа эзэмшигч нь давуу эрхийн хувьцаатай буюу саналын эрхгүй байдаг. Тэд ногдол ашиг авахаас биш компанийн үйл ажиллагаанд өдөр тутам оролцдоггүй. Монгол ийм жишигт нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулбал зүйтэй юм шиг санагддаг.



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАХ ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧГИЙГ БҮРТГЭХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан бөгөөд энэхүү төлөвлөгөөний 2 дахь зорилтын 2.1-т заасан арга хэмжээний хүрээнд Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгохоор болсон. Нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн, эсвэл нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдсөн, банкнаас зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд тавигдсан бусад шаардлагыг хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага болон банкнаас зээлийн үйл ажиллагааны журам, зааврын хүрээнд тавигдсан шаардлагыг хангасан хувиараа үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхлэгч Монгол Улсын иргэнд нийт 2.0 их наяд хүртэл төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаатай, 3.0 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй олгох бөгөөд нийт олгох зээлийн 30.0 хүртэл хувийг ижил зориулалттай олгогдсон зээлийн дахин санхүүжилтэд ашиглаж болохоор, ажлын байрыг дэмжих хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагад олгох зээл 500.0 сая төгрөг хүртэл, иргэнд олгох зээл 50.0 сая төгрөг хүртэл хэмжээтэй байх ба Засгийн газраас аж ахуйн нэгжид олгосон зээлийн нийт хүүгийн 6.0 нэгж хувийг, иргэнд олгосон зээлийн нийт хүүгийн 7.0 нэгж хувийг хариуцан төлж дэмжлэг үзүүлэхээр тус тус заасан байна.

ББСБ-ууд нь итгэлцлийн үйл ажиллагаа, банк, санхүүгийн байгууллагын зээл, төслийн зээлийн санхүүжилт, өрийн бичиг гаргах, хоёрдогч өглөгөөр нэмэлт эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжтой бөгөөд итгэлцлийн үйл ажиллагаа, хоёрдогч өглөг, нээлттэй өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг авч, үргэлжилсэн хяналт тавьж байна.

Харин хаалттай өрийн бичиг гаргах тохиолдолд Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно”, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг гаргаж болно” гэж тус тус заасны дагуу холбогдох гэрээ, хэлцлийг үндэслэн эх үүсвэр татах боломж нь чөлөөтэй байна. Сүүлийн жилүүдэд ББСБ-ууд нээлттэй болон хаалттай хэлбэрээр өрийн бичиг гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлэх болсон бөгөөд тухайлбал 2016 оны байдлаар 7

ББСБ 4.1 тэрбум төгрөгийн өрийн бичгийн үлдэгдэлтэй байсан бол 2021 онд энэхүү үзүүлэлт 31 ББСБ-ын 62.5 тэрбум төгрөгт хүрч 14.3 дахин өссөн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 199 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”, 2012 оны 248 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ыг тус тус баталж, мөрдүүлж байсан бөгөөд энэхүү журмыг 2015 оны 409 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна.

Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглах, зарцуулалтад хяналт тавих, банк бус санхүүгийн байгууллагын салбарт өрийн бичиг татах, бусад хэлбэрээр байршуулахаас сэргийлэх, нөгөөтэйгүүр өрийн бичгийг нэгдсэн бодлогоор зохицуулах, тэдгээрийг бүртгэлжүүлэх замаар учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг сайжруулах, нөгөө талаас төрийн байгууллагуудын мэдээллийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.13 дахь хэсэгт “Санхүүгийн зохицуулах хороо эрсдэл үүссэн, зайлшгүй нөхцөл байдлын үед санхүүгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тусгайлан шаардлага тавьж, хязгаарлалт хийнэ” гэж заасны дагуу энэхүү журмыг баталсан.


ХОЁР. Салбарын өнөөгийн байдал

2020 оны жилийн эцсийн байдлаар 31 ББСБ нээлттэй болон хаалттай хүрээнд өрийн бичиг гаргаж, үүнийг 783 хувь хүн, хуулийн этгээд худалдан авсан ба нийт 62.5 тэрбум төгрөгийн өрийн бичгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт. ББСБ-аас гаргасан өрийн бичиг /тэрбум төгрөгөөр/

ББСБ-ААС ГАРГАСАН ӨРИЙН БИЧИГ	Дүн	Итгэл цэлтэй ББСБ	Уламжлалт зээл ББСБ	Финтек зээл ББСБ	УБ	ХОН	ХК	ХХК	ГХО
	62.5	54.4	35.8	26.7	62.5	0.0	18.8	43.7	16.7
Төгрөгөөр	53.5	46.3	34.5	19.0	53.5	0.0	17.1	36.4	10.6
Валютаар	9.0	8.1	1.3	7.7	9.0	-	1.7	7.3	6.0

Зураг. Өрийн бичгийн үлдэгдэл сүүлийн 5 жилийн байдлаар / тэрбум төгрөгөөр/



Өрийн бичгийн үлдэгдэл 2016 оны мөн үеэс 14.3 дахин өсөж 62.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн өмнөх оны мөн үед валютаар гаргасан өрийн бичгийн нийт өрийн бичгийн үлдэгдэлд эзлэх хувийн жин 6.1% байсан бол 2020 оны жилийн эцсийн 8.3 пунктээр өсөж 14.4%-д хүрсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2016.IV	2017.IV	2018.IV	2019.IV	2020.IV
Итгэлцлийн өглөг	30.5	39.2	57.6	108.3	146.9
Банк, санхүүгийн байгууллагын зээл	121.4	112.8	151.0	207.6	171.2
Өрийн бичиг	4.1	6.9	23.5	41.8	62.5
Төслийн зээлийн санхүүжилт	21.4	14.9	17.8	17.6	20.8
Хоёрдогч өглөг	1.0	0.7	1.0	0.8	0.8
НИЙТ ӨРТӨГ БҮХИЙ ЭХ ҮҮСВЭР	178.3	174.4	250.9	376.1	402.2

Дээрх мэдээллээс үзэхэд өртөг бүхий эх үүсвэрийн хэмжээ 2016 оны мөн үеэс 1.2 дахин өссөн байх ба өр төлбөрт эзлэх өрийн бичгийн хэмжээ 2016 онд 2.3 хувийг эзэлж байсан бол 2020 онд 15.5 хувьд хүрч өссөн байна.

ГУРАВ. Журмын орилго, ерөнхий бүтэц, зохицуулсан харилцааны талаар

Нэг. Журмын зорилго:

Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо / цаашид “Хороо” гэх/-ноос банк бус санхүүгийн байгууллага/ цаашид “ББСБ” гэх/-ын хаалттай өрийн бичиг гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, түүнийг бүртгэх, бүртгэхээс татгалзах, хасах, ББСБ-ын эрх үүргийг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Журмын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа: Журам нь дор дурдсан бүтэцтэй байх бөгөөд дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт журмын зорилгыг тусгасан. Хоёрдугаар бүлэгт хаалттай өрийн бичиг гаргах ББСБ-д тавигдах шаардлагыг тогтоож, хүсэлт тавихад шаардагдах баримт бичгийн бүрдүүлбэрийг тодорхойлсон. Мөн хаалттай өрийн бичгийн эрсдэлийг бууруулах зорилгоор баталгаа, даатгалд хамрагдсан байж болох төрлийг тодорхойлж, өрийн бичиг эзэмшигчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар болон өрийн бичиг гаргагч, эзэмшигчид хориглосон үйл ажиллагааг тусгаж өгсөн.

Гуравдугаар бүлэгт хаалттай өрийн бичгийг бүртгэх, бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах нөхцөл, шаардлагыг тодорхойлсон.


Дөрөвдүгээр бүлэгт хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ-ын эрх, үүрэг, харилцагчийн хувийн хэрэг бүрдүүлэлтийн талаар тусгасан.

Тавдугаар бүлэгт хаалттай өрийн бичиг гаргах гэрээний эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Зургаадугаар бүлэгт хяналт, хариуцлагын талаар тусгасан.

ДӨРӨВ. Журмаар зохицуулсан харилцааны үр нөлөөллийн талаар

Энэхүү журмыг баталснаар нээлттэй болон хаалттай өрийн бичгийн зах зээлийг нэгдсэн удирдлагаар хянаж, зохицуулах, тэдгээрийг бүртгэлжүүлэх замаар өрийн бичиг эзэмшигчдийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нөгөөтээгүүр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, мэдээллийн урсгалыг сайжруулах, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглах, зарцуулалтад хяналт тавих, банк бус санхүүгийн байгууллагын салбарт өрийн бичиг татах, бусад хэлбэрээр байршуулахаас сэргийлэх, хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалсан зохицуулалт болно гэж үзэж байгаа болно.



ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

НОГООН, ДИЖИТАЛ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛЖИЛТ

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт Н.Нарантуяа

Уншигч та бүхэндээ тогтвортой санхүүжилт булангаараа байгаль орчин, нийгэмд ээлтэй хөрөнгийн зах зээл, түүний экосистемийн талаар өмнөх дугааруудад хүргэж байсан бол энэ удаад тогтвортой санхүүжилтийн цар хүрээг нэмэгдүүлэхэд тулгардаг бэрхшээл, түүнийг дижитал дэвшлээр шийдвэрлэж буй талаар хүргэе.

Ногоон, нийгмийн болон тогтвортой бонд гаргах, хувьцаат компаниуд байгаль орчин, нийгэмд ээлтэй үйл ажиллагаа явуулах аль ч тохиолдолд дараах сорилтуудтай нүүр тулдаг:


- Мэдээллийн ил тод байдлаа нэмэгдүүлэх;
- Хөрөнгө оруулагчдын эрэлтэд нийцсэн ногоон үнэт цаас гаргах;
- Ногоон бүтээгдэхүүний хөрвөх чадвар хангалтгүй;
- Ногоон санхүүжилтийн талаарх ойлголт бага.

Тогтвортой хөрөнгийн зах зээлийн орчинд үнэт цаас гаргагчдын хувьд тайлагнал, хариуцлага нэмэгдэх ба үүний технологийн шийдлээр хялбарчлах боломж бий. Учир нь байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн мэдээлэл дутагдалтай байдгийн улмаас мэдээллийн тэгш бус байдал үүсэн, тухайн мэдээллийг олж авахад нэмэлт цаг болон зардал зарцуулдаг. Харин дижитал санхүүжилт буюу их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мобайл платформ, блокчэйн, интернет дэх


зүйлс (IoT) нь дээрх асуудлуудыг шийдвэрлэж, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжлийг дэмжинэ. Ингэснээр дижитал шилжилт нь хөрөнгө оруулагчдад байгаль орчин, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийн талаарх мэдээллийг хүргэж зардал хэмнэх, эрсдэлийг эрт илрүүлэх, инноваци, хүртээмжийг нэмэгдүүлэх, олон нийтийг санхүүгийн зах зээлийн гинжин хэлхээнд оролцох боломжийг бүрдүүлдэг.

“Хөрөнгийн зах зээлийн хувьд дижитал шилжилт нь тархмал бүртгэлийн системд суурилан хийгддэг мэдээллийг сүлжээний оролцогч бүрээр хадгалдаг технологи бөгөөд уламжлалт өгөгдлийн сангийн системээс ялгарах гол ялгаа нь төвлөрсөн өгөгдлийн сан болон төвлөрсөн удирдлагын функцгүй. Уг систем нь мэдээллийг хурдтай, хямд дамжуулахаас гадна цахим халдлагад өртөх магадлалыг багасгадаг” (СЗХ, ҮЦГ. “Тархмал бүртгэлийн системд суурилсан нэгдсэн цахим биржийг нэвтрүүлэх боломж”. 2021 он). Түүнчлэн тархмал бүртгэлийн системийг ашиглан дижитал хөрөнгийн биржийн үйл ажиллагааг явуулснаар брокер, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж болон кастодиан зэрэг зуучлал, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааг технологиор орлуулснаар арилжааны шимтгэлийн зардал буурдаг.

Тогтвортой санхүүжилтэд технологийн дэвшлийг хөрөнгийн биржүүд хэдийнээ хэрэглээд эхэлсэн ба ногоон хөрөнгөд



Төвлөрсөн бүртгэл



Тархмал бүртгэл

суурилсан виртуал хөрөнгийг ч гаргахад бэлтгээд байна. Одоогийн байдлаар Люксембургийн ногоон хөрөнгийн бирж блокчэйн технологийг мэдээллийн тайлагналд ашиглаж байгаа бол Сингапурын Сибердин тек бирж нь ногоон дэд бүтцийн хөрөнгөд суурилсан токены арилжаа явуулах юм.



**LUXEMBOURG
STOCK EXCHANGE**

Люксембургийн ногоон хөрөнгийн бирж: Люксембургийн хөрөнгийн биржээс 2016 онд Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн орчныг бий болгох зорилгоор Люксембургийн ногоон хөрөнгийн биржийг байгуулж, тогтвортой үнэт цаас гаргах платформыг нээсэн. Уг бирж нь нийт тогтвортой санхүүжилтийн тал хувийг хөрөнгө оруулалтаар татсан ба санхүүгийн тайлагналын сувагтаа илүү найдвартай, хурдан, зардал багатай блокчэйд

суурилсан тархмал бүртгэлийн системийг нэвтрүүлсэн.



Cyberdyne Tech Exchange

Сибердин тек бирж: Тус бирж нь 2018 онд байгуулагдаж, Сингапурын Мөнгөний Хорооноос тусгай зөвшөөрлөө авснаар анхны зохицуулалттай дижитал хөрөнгийн биржийн үйл ажиллагаа явуулж, альтернатив хөрөнгө оруулалтын хэрэгсэл арилждаг болсон. Тэдгээр бүтээгдэхүүний нэг нь тогтвортой хөдөө аж ахуй, барилга, ногоон үйлдвэрлэл зэрэг ногоон хөрөнгөд суурилсан токеныг гаргаж, арилжих юм. Түүнчлэн хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагч гэсэн хоёр талаас хүлэмжийн хийн ялгаруулалтын тайлагналыг гаргуулж, экологийн ул мөрийг багасгахад зорьсноор уламжлалт хөрөнгийн биржээс давуу талтай. Түүнчлэн уг бирж нь блокчэйн технологи, ухаалаг гэрээ ашиглан хөрөнгийг токенжуулах тул хөрвөх чадвар багатай, өндөр үнэ цэнтэй хөрөнгөд суурилан үнэт цаасны токен гаргадаг. Тиймээс хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө худалдан авах боломжийг нэмэгдүүлж, үнэт цаас гаргагчдад уламжлалт хандлагатай харьцуулахад хямд, хурдан, хялбар аргаар хөрөнгө татах боломж олгосон.



ФИНТЕК БА РЕГТЕК



Цахим гэмт хэрэгтэн, хакеруудын хувьд технологи өдрөөс өдөрт шинэчлэгдэж байгаа нь санхүүгийн байгууллагуудын хуучирсан технологи, ажилтны гаргасан алдааг “ашиглан” олон сая ам.долларын алдагдал, зах зээл дээрх нэр хүндийг унагах зэрэг зохион байгуулалттай үйл ажиллагааг явуулах боломжийг бий болгодог. Финтек компаниудын хувьд шинэ технологийг ашиглагдаараа дараах хэд хэдэн асуудал, эрсдэлтэй тулгардаг.

Үүлэн тооцооллын асуудал: Төлбөр, дижитал банк, хэтэвчийн үйлчилгээ ихэвчлэн үүлэн тооцооны платформоор дамжиж хийгддэг. Үүлэн тооцоолол нь хамрах хүрээ, хурд сайтай, нэвтрэхэд хялбар зэрэг давуу талуудтай ч цахим халдлагад халхавч болгож ашиглах ч тохиолдлууд гардаг. Иймээс үндсэн дата төвүүдээс тусад нь байлгах шаардлагатай байдаг бөгөөд найдвартай, олонд танигдсан үүлэн системийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгох хэрэгтэй.

Гуравдагч этгээдийн хандалт: Банк, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаа, аппликэйшндээ гуравдагч этгээдээс үйлчилгээ, програм хангамжийг авч ашигладаг. Эдгээр аппликэйшнээр дамжуулан цахим гэмт хэрэгтнүүд банкны мэдээллийн системд халдах боломжтой болдог. Иймээс өмнөхийн адил гуравдагч этгээдийг сонгохдоо анхаарч, тэдгээрийн хандах мэдээллийн хүрээг хязгаарлах шаардлагатай болдог.

Системийн нарийн төвөгтэй болон нийцтэй байдал: Томоохон банк, санхүүгийн байгууллагууд хил дамнасан үйл ажиллагаа явуулж, бусад улсуудад өөрийн салбар, төлөөлөгчдийн газрыг байгуулдаг. Харин тэдгээрийн үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг, улс орон бүр харилцан адилгүй хөгжүүлэлт, дэд бүтцээр хангагдсан байдаг. Эдгээр системүүдийн уялдаа холбоо байнга тохироод байдаггүй учир сүлжээнд “цоорхой” үүсгэдэг. Энэхүү цоорхой цахим халдлагад өртөх нь элбэг байдаг.

Вирусийн халдлага: Компьютерийн вирус нь хамгийн түгээмэл хэлбэр бөгөөд өдрөөс өдөрт технологийн хамт хөгжин, илрүүлэх, устгахад илүү хэцүү болсоор байна. И-мэйл, хөндлөнгийн програм хангамж, вебсайт зэрэг олон эх үүсвэрээс вирусийг авах эрсдэлтэй бөгөөд гол аюул нь өндөр хурдаар тархдаг учир бүтэн систем, сүлжээг унтраах аюултай.

Мөнгө угаах эрсдэл: Криптовалютын нэр хүнд сүүлийн жилүүдэд өсөж, хэрэглэгчдийн тоо нэмэгдэж байгаа нь нэг талаараа финтек компаниудын хувьд эрсдэлийг дагуулж

байна. Криптовалютын урсгалаар орж ирж буй мөнгөн урсгалын гарал үүсэл нь үл мэдэгдэх бөгөөд хууль бус аргаар олсон мөнгөө угаахад ашиглаж эрсдэлтэй байдаг. Цаашилбал криптовалютын гүйлгээ нь мэдээллийн хулгайд зориулж хакеруудын зохион бүтээсэн луйвар, нэвтрэх цэг байж болох бөгөөд энэ нь хууль сахиулах байгууллагуудад ихээхэн алдагдал, асуудал үүсгэдэг.

Хувь хүн, хуулийн этгээдийн мэдээллийг ашиглах: Банк, санхүүгийн байгууллагууд пин код, нууц үг, биометрик зэрэг харилцагчийг баталгаажуулах аргыг үйлчилгээний аюулгүй байдалд ашигладаг. Гэсэн хэдий ч эдгээр аргуудын сул тал нь хувь хүн, хуулийн этгээдийн мэдээлэл алдагдсан эсвэл хуулбарлагдсан /identity theft/ тохиолдолд их хэмжээний мөнгөний алдагдалд хүргэх эрсдэлтэй.

Онлайн дижитал платформ: Ихэнх банк, санхүүгийн байгууллагууд онлайн платформ руу шилжсэн ба ингэснээр хэрэглэгчид өөрсдийн данстай харьцахад гар утас, компьютероор дамжуулдаг. Хэдийгээр банк, санхүүгийн байгууллагын сүлжээ найдвартай байсан ч харилцагчийн ашиглаж буй төхөөрөмжид гарах зөрчил, асуудлыг илрүүлэх боломжгүй байдаг.

Банкны системийн шилжилт: Банк, санхүүгийн байгууллагууд уламжлалт байдлаасаа илүү дэвшилтэт, хурдтай систем рүү шилжиж байгаа хэдий ч гол асуудал нь ингэх явцад системийн аюулгүй байдлыг хангаагүй, орхигдуулсан тохиолдолд цахим халдлагад өртөх магадлал өндөртэй байдаг. Иймээс шинэ технологид шилжихдээ тодорхой шат дараатайгаар мөн аюулгүй байдлыг хангасан байхыг баримтлах ёстой.

Цахим аюулгүй байдлын санхүүжилт, ач холбогдол: Санхүүгийн зах зээл өрсөлдөөн өндөртэй бөгөөд харилцагчдын үнийн өөрчлөлтөд мэдрэг байдгаас шалтгаалан үйл ажиллагааны зардлаа танах, бууруулах тохиолдлууд их байдаг. Энэ тохиолдлуудад ихэвчлэн ач холбогдол төдийлөн өгдөггүй цахим аюулгүй байдал зэргийн санхүүжилтийг багасгаж, зардлыг бууруулах арга хэмжээ авдаг. Учир нь хурдацтай өөрчлөгдөж буй технологид тааруулж дэд бүтэц, системийг өөрчлөх нь бусад үйл ажиллагаатай харьцуулахад зардал өндөртэй байдаг. Гэсэн хэдий ч цахим халдлагад өртөх нь аюулгүй байдалд зарцуулахаас илүү хохиролтой байх учир энэ чиглэлийн зардлыг бууруулахгүй байх нь зүйтэй.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗОХИЦУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАГЧИЙН ЗАСАГЛАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА, ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА (ЭЗХАХБ)-ЫН ЗӨВЛӨМЖ



Зохицуулалтын чанарын тухай төрийн цогц бодлогыг улс төрийн дээд түвшинд хэрэгжүүлэх. Сайн зохицуулалттай бодлогыг төр хэрэгжүүлбэл эдийн засаг, нийгэм, байгаль орчинд өгөх үр ашиг нь зардлыг багасгах, хуваарилалтын үр нөлөөг тооцох, цэвэр ашгийг хамгийн дээд хэмжээнд байлгах зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжтой бөгөөд уг бодлого нь тодорхой зорилт, хүрээг

хамарсан байх ёстой. Бодлогын зорилтыг тодорхойлохоос эхлээд зохицуулалтын загвар гаргах, үнэлэх, шийдвэр гаргалтуудад бодлогын тасралтгүй мөчлөгийг бий болгон, хэрэгжүүлэх шаардлага үүснэ.

Зохицуулалт нь олон нийтийн ашиг сонирхолд нийцэхийн сацуу түүнд хамрагдах сонирхол бүхий, эсхүл хамрагдсан этгээдийн хууль ёсны мэдээллийн хэрэгцээг хангахын тулд зохицуулагч байгууллагын энэхүү үйл явцад оролцоходоо баримтлах зарчмыг ил тод, нээлттэй байлгана. Үүнд, иргэд, олон нийт зохицуулалтын шийдвэрийн төслийг боловсруулах явцад өөрийн эрх ашиг, сонирхол, санал хүсэлт тусгуулах замаар дэмжлэг үзүүлэх боломжтой. Зохицуулагч байгууллага нийтээр даган мөрдөх захиргааны хэм хэмжээний актуудыг оролцогч талуудад ойлгомжтой, хүртээмжтэй болгосноор талууд өөрсдийн эрх, үүргээ сайн ойлгодог байх ёстой.

Зохицуулалтын журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг идэвхжүүлснээр зохицуулалтын бодлогыг дэмжин, ажил хэрэг болгох, улмаар зохицуулалтын чанарыг дэмжих дэд бүтцийг бий болгох хэрэгтэй. Хяналт, зохицуулалтын байгууллагын эрх мэдлийг хууль тогтоомжийн хүрээнд маш тодорхой зааж өгөх ба захиргааны эрх хэмжээний актуудаар зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ, гүйцэтгэлийг сайжруулах стратегийн талаар сургалт, удирдамжийг өгөх шаардлагатай.

Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээг тухайн зохицуулалтын төсөл боловсруулах эхний үе шатанд гүйцэтгэх ба бодлогын зорилтыг тодорхойлж, тухайлсан зохицуулалт шаардлагатай эсэх, тэдгээр зорилтуудад хэрхэн хамгийн үр дүнтэйгээр хүрч болохыг тооцоолдог. Ингэхдээ зохицуулалтын арга хэрэгслүүдийн хамгийн үр ашигтай хандлагыг тодорхойлоход анхаарч, суурь судалгаа, дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлага үүснэ.

Ямарваа нэг зохицуулалтын өртөг, зардал нь үндэслэл бүхий, төлөвлөсөн бодлогын зорилтыг биелүүлэхийн тулд зардал болоод ашгийг тус тус харгалзан тухайн зохицуулалтын системчилсэн хөтөлбөрийн үнэлгээг хийх нь зохистой.

Мөн зохицуулалтын бодлого, шинэчлэлийн хөтөлбөрийн гүйцэтгэл болоод тухайн зорицуулалтын хэрэгжилтэд хяналт тавьж буй байгууллагуудын гүйцэтгэлийн тайланг тогтмол олон нийтэд хүртээл болгоно. Энэхүү тайланд зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ, олон нийтийн дунд зохион байгуулсан нээлттэй хэлэлцүүлэг, одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журмын зохицуулалт зэрэг

зохицуулалтын бүхий л хэрэгслүүдийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг багтаадаг.

Зохицуулалтын шийдвэрийг ашиг сонирхлын зөрчилгүй, тууштай, нэг талыг бариагүй, объектив хандлагын үндсэн дээр гардаг гэдгийг тодорхой батлахын тулд зохицуулагч байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэгт нийцсэн тууштай бодлогын баримтыг боловсруулан, хэрэгжүүлэх нь зүйтэй.

Зохицуулагч эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, зохицуулалтын дүрэм, журмын ил тод, шударга байдлыг хяналтын системээр баталгаажуулах бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүдэд эдгээр хяналтын системд чөлөөтэй нэвтрэх, аливаа захиргааны шийдвэрийг цаг тухайд нь хүлээн авах боломжийг олгох ёстой.

Эрсдэлийн үнэлгээ, түүний удирдлага, эрсдэлийн стратегийг зохих түвшинд боловсруулж, хэрэгжилтэд нь анхаарах хэрэгтэй. Зохицуулагч нь өөрийн гаргасан зохицуулалтын шийдвэрээ хэрхэн хэрэгжиж буйг үнэлж, шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээ авах буюу түүнийг удирдах эрсдэлийн стратегийг боловсруулдаг. Зохицуулагч олон нийтэд зориулсан мэдэгдэл гаргахдаа гарч болох эрсдэл, тухайн зохицуулалтын шийдвэрийн талаар баримтлах стратегийг багтаах шаардлагатай. Мөн зохицуулагч нь бусад оролцогч талууд, олон нийтийн хууль ёсны эрх ашиг, хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлийн үнэлгээ, удирдлага, хамтын ажиллагаа, харилцааны аргачлалын удирдамжийг боловсруулж, тогтмол шинэчилдэг байх ёстой.

Зохицуулагчийн зүгээс тухайн бизнесийн салбарын хэмжээнд менежментийн чадавх, гүйцэтгэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй ба шударга бус өрсөлдөөнийг хязгаарлаж, хөрөнгө оруулалт, бизнесийн өсөлт, ажлын байр бий болгоход саад болж буй орон нутгийн болон бус нутгийн түвшинд зохицуулалтын зардал, аливаа бэрхшээлийг бууруулахын тулд зохицуулалтын бодлого, хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд Засгийн газар дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй. Зохицуулалтын арга хэмжээг боловсруулахдаа олон улсын холбогдох бүх стандарт, оролцогч талуудын хамтран ажиллах хүрээг харгалзан үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг анхааран ажиллах шаардлагатай ба даяаршиж буй эдийн засагт олон улсын зохицуулалтын хамтын ажиллагаа нь эрсдэлийн системийн удирдлага, урт хугацааны бодлого төлөвлөлтийн салшгүй хэсэг болох нь зүй юм.



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХЯТАД УЛС КРИПТО-ВАЛЮТЫГ ХОРИХ ҮЕД БИТКОЙНЫ ҮНЭ УЛАМ УНАВ.

5 дугаар сарын 13-ны өдөр Хятад улс крипто-валютууддаа шинэ хориг тогтоосны дараа Биткойны үнэ гурван сарын хугацаанд анх удаа 34,000 доллараас (24.030 фунт) –ээс доош унав. Бээжин банк, төлбөрийн байгууллагууд криптовалютын гүйлгээтэй холбоотой үйлчилгээ зүүлэхийг хориглосон. Түүнчлэн 5 дугаар сарын 12-ны өдөр крипто арилжаа хийхээс сэрэмжлүүлэхийг хөрөнгө оруулагчдад анхаарууллаа. Тесла криптовалют хүлээн авахаа болино гэж хэлсний дараа Биткойны ханш 10-аас дээш хувиар унав. 5 дугаар сарын 19-ний өдрийн үдээс хойш биткойны ханш бага зэрэг сэргэсэн ч, энэ нь -10.4% –иас доош хэвээр, 38.131 доллар байна.

Үүний зэрэгцээ, Ethereum блокчейн сүлжээнд түлшний үүрэг гүйцэтгэдэг Ether гэх мэт дижитал валютууд болон Dogecoin нь 22% ба 24% –ийг алдсан байна.

БЭЭЖИНД ХАТУУ ХОРИЛОО


Хятадад мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор 2019 оноос хойш крипто-валютын арилжаа хууль бус байсан. Гэхдээ хүмүүс биткойн гэх мэт валютаар онлайнар худалдаа хийх боломжтой хэвээр байна.

Хятадын Үндэсний Интернэт Санхүүгийн Нийгэмлэг, Хятадын Банкны Холбоо, Хятадын Төлбөр тооцооны нийгэмлэг зэрэг төрийн дэмжлэгтэй гурван байгууллага олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг гаргажээ. Тэд хэрэглэгчид крипто-валютын хөрөнгө оруулалтын гүйлгээнээс болж алдагдал хүлээх тохиолдолд ямар ч хамгаалалтгүй болно гэж мэдэгдэв.

Тэд сүүлийн үед криптовалютын ханшийн огцом хэлбэлзэл "хүмүүсийн хөрөнгийн аюулгүй байдлыг ноцтой зөрчиж", "эдийн засаг, санхүүгийн хэвийн байдал"–ыг алдагдуулж байна гэж нэмж хэллээ.

Markets.com сайтын Нейл Вилсон хэлэхдээ "Хятад улс хэсэг хугацаанд крипто валютын орон зайд шахалт үзүүлж ирсэн боловч энэ нь улам эрчимжиж байгааг харуулж байна. Төв банкууд өөрсдийн дижитал валют руу нэг алхам урагшилсан тул бусад улс орнууд дагаж магадгүй юм. "Өнөөг хүртэл барууны зохицуулагчид Bitcoin-ийн талаар нэлээд тайван байсан боловч энэ нь удахгүй өөрчлөгдөж магадгүй юм."

Зураг. Биткойн нь 2021 онд олсон ашигш(Валютын ханш ам.доллараар)



Эх сурвалж: BBC

ТЭСЛАГИЙН ШИЙДВЭР

Гуравдугаар сард Теслагийн захирал Элон Маск цахилгаан үйлдвэрлэгч компани хэрэглэгчиддээ Биткойн ашиглан автомашин худалдаж авах боломжийг олгоно гэж гэнэт мэдэгдсэн.

Харин 5 дугаар сард эргэлт хийж, байгаль орчны асуудалтай холбогдуулан Биткойн ашиглан тээврийн хэрэгсэл худалдан авахаа түр зогсоосон байна.

Тэр Биткойн олборлолтод санаа зовж байгаа бөгөөд энэ нь өндөр хүчин чадалтай компьютер ашиглан дижитал валют бий болох эрчим хүч их шаарддаг үйл явц юм. Энэ нь ихэвчлэн ашигт малтмал түлшээр, ялангуяа нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүч дээр тулгуурладаг. "Биткойны олборлолт, гүйлгээнд ашигт малтмалын түлшний хэрэглээ, ялангуяа хамгийн муу ялгаруулдаг нүүрсний түлшний хэрэглээ нэмэгдэж байгаад бид санаа зовж байна." гэж ноён Маск бичжээ. "Криптовалют бол сайн санаа юм. Гэхдээ энэ нь байгаль орчинд маш их өртөгтэй байж болохгүй." Түүний хэлснээр цахилгаан автомашин үйлдвэрлэгч компани өөрийн биткойныг зарах бодолгүй байгаа бөгөөд олборлолт илүү тогтвортой эрчим хүчний эх үүсвэр ашиглахаар шилжсэний дараа крипто-валютын гүйлгээг сэргээхээр төлөвлөж байна гэжээ.


Хятадад дижитал валютыг арилжаалах боломжгүй ч дэлхий даяарх Биткойн олборлолтын 75%-аас илүү хувийг Хятадад хийдэг.

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 06 дугаар сарын 27-ны өдөр

S&P 500 /[^]GSPC/


4,195.99 +7.86 (+0.19%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /[^]N225/


28,549.01 -93.18 (-0.33%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /[^]FTSE/


7,026.93 0.00 (0.00%)




Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite ([^]IXIC)

13,738.00 +80.79 (+0.59%)




Эх сурвалж: www.finance.yahoo.com

 Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

 +976-51-264444

 press@frc.mn

 www.frc.mn

 Санхүүгийн зохицуулах хороо